**МОНГОЛ УЛСЫН**
**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ**
**САЙДЫН ТУШААЛ**

2010 оны 03 сарын 03 өдөр Дугаар 89 Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 тоот тогтоолоор баталсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад сургах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2009 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 336 дугаар тушаалын Ганбатын Батчимэгтэй холбогдолтой хэсгийн “АНУ-ын Лос-Анжелос хотын Калифорни хотын улсын их сургуулийн магистрантурт боловсрол удлалын чиглэлээр” гэснийг “АНУ-ын Virginia International их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр” гэж өөрчилсүгэй.

2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД Ё.ОТГОНБАЯР